



ӨСВӨР НАСНЫ ХҮНД ОНОГДУУЛСАН НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS ON THE EXERTION OF COMMUNITY SERVICE SENTENCING FOR JUVENILES

Чойсүрэнгийн Нансалмаа*

Дотоод хэргийн их сургуулийн магистрант, ахлах дэслэгч

SR. Lt. Nansalmaa Choisuren, MA scholar, University of Internal Affairs

Алтангэрэлийн Жандаг

Дотоод хэргийн их сургуулийн магистрант, хошууч

Maj. Jandag Altangerel, MA scholar, University of Internal Affairs

*хариуцлагатай зохиогч: choisurennansaa@gmail.com

Хураангуй: Монгол Улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хийгдсэн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Эрүүгийн хуулийн "Албадан ажил хийлгэх ял"-ын төрлийг "Нийтэд тустай ажил хийлгэх ял" болгон ялын хэлбэрийг өөрчлөн томьёолсон.

Хорихоос өөр төрлийн ялыг илүү чухалчлах болсон нь нэг талаас ялын бодлогод хүмүүнлэгийн чиг хандлага түгээмэл нэвтэрсэн, нөгөө талаас хүний эрхийн үнэт зүйлсийг эрүүгийн эрх зүйгээр хамгаалах шаардлага өсөн нэмэгдэж ирсэнтэй холбоотой байна.

Иймд дээрх эрдэмтэн, судлаачдын бүтээл туурвилуудыг харьцуулан судалж, системчлэх, статистикийн аргуудыг ашиглан энэхүү илтгэлээ бичлээ.

Монгол Улсын эрүүгийн ялын бодлогын чиг хандлага хорих ялаас татгалзаж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр үйлдсэн гэмт хэргийн хор уршигт тохируулан хорихоос өөр төрлийн ял оногдуулах болсонтой холбоотой нийтэд тустай ажил хийлгэх ял сүүлийн жилүүдэд ихээхэн анхаарал татаж байна.

Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хэрхэн үр дүнтэй эдлүүлэх асуудлыг боловсронгуй болгох, тэр тусмаа насанд хүрээгүй буюу өсвөр насны хүнд оногдуулсан тохиолдолд хэрхэн эдлүүлэх талаар ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, сайжруулах арга замыг тодорхойлоход оршино.

Abstract: Mongolia revised its Criminal Code in 2015, and legalized the type of punishment previously known as "Forced Labor" as a new type of punishment called "Community Service".

Emphasizing on punishments other than incarceration is due, on the one hand, to the widespread adoption of humanitarian trends in punishment policy, and, on the other hand, to the growing need to protect human rights values through criminal law.

In Mongolian legal science, there have been studies on the types of punishments, including imprisonment, fines, and death penalty, but a comprehensive work that specifically studies the issue of community service has not yet been published, and many problems have accumulated in the use of this punishment in current judicial and court enforcement practice, and they are still waiting for solutions.

Community service has attracted much attention in recent years due to the trend in Mongolian criminal punishment policy to abandon imprisonment and impose other types of punishments that are appropriate to the consequences of the crime committed without isolating the offender from society. The issue of how to effectively serve community service sentences, especially when they are imposed on minors or adolescents, has been discussed in the context of the sentencing process.

Түлхүүр үгс: Өсвөр насны хүн, ял, үр нөлөө, ялын төрөл.

Keywords: Adolescence, sentence, efficiency, sentence type.

Удиртгал

Олон улс төдийгүй Монгол Улсын нийгмийн харилцааны явцад бусдад болон нийгэмд хор нөлөөтэй үйлдэл, эс үйлдэхгүйг үйлдсэн хэн бүрд хариуцлага тооцож, гэмт үйлдлийн улмаас учирсан хохирлыг арилгах арга хэмжээг тооцож ирсэн. Энэ нь зарчмын хувьд зүйн хэрэг хэдий ч хэнд хэрхэн ямар шийтгэл оногдуулах нь харилцан адилгүй байх нь гарцаагүй юм. Монгол улсын Эрүүгийн хуульд заасан ялын төрөлд “нийтэд тустай ажил хийлгэх ял” (Эрүүгийн хууль, 2016) -ыг багтаан хуульчилсан нь өмнөх хуулиас ололт дэвшил гарсан ихээхэн ач холбогдолтой юм. Гэхдээ өсвөр насны хүнд оногдуулсан ял хэрэгжүүлэх ажиллагаа тодорхой бус ерөнхий байдлаар тусгагдсан байна. Өсвөр насны хүнийг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх нь хууль ёсны үзэл баримтлал хэдий ч хүүхдийн нас биеийн онцлогт тохирсон шийтгэлийг хүлээлгэх нь дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх чухал асуудал юм. Одоогоор нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагааг зохион байгуулахдаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын баталсан жагсаалтын дагуу төрийн байгууллагад цалин хөлсгүйгээр ажил эрхлүүлж ял эдлүүлж байгаа.

Өсвөр насны хүнд оногдуулсан нийтэд тустай ажил хийлгэх ялыг хэрэгжүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зохион

байгуулалтын асуудлыг хөндсөнөөр цаашид энэ ялын хэрэгжилтийн үр нөлөөг олон чиглэлээр нэмэгдүүлэх ач тустай гэж үзлээ. “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 7 дугаар зорилтын 7.4.8-д “Ял шийтгэгдсэн хүнийг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх, нийгмээс тусгаарлахгүйгээр ялын бодлогыг хангах зорилгоор “Цахим хяналтын төв”-ийг байгуулж, пробацын тогтолцоог хөгжүүлнэ” (Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2020) хэмээн тусгасан нь хорихоос өөр төрлийн ял нийтэд тустай ажил хийх ялын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, цаашид засан сайжруулах, өсвөр насны хүний эрх ашгийг хохироохгүйгээр ял эдлүүлэх, нийгэмд эерэг үр дагаврыг бий болгох, ирээдүй хойч үеэ зөв хүн болж төлөвших нөхцөлийг бүрдүүлэх нөхцөл боломжийг эрэлхийлэх үндэслэл болж байна.

Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаанд ялын төрлүүдээс хорих ял, торгох ял болон цаазаар авах ялын чиглэлээр дагнасан судалгаа хийгдсэн бөгөөд Г.Совд, Ж.Амарсанаа, С.Нарангэрэл, С.Жанцан, Б.Баярсайхан, Д.Булган зэрэг монгол улсын эрдэмтэд Насанд хүрээгүй хүнд оногдуулах эрүүгийн харицулагын талаар, Б.Алтангэрэл, А.Лхагва, Э.Батбаяр, Ц.Очгэрэл, Б.Галбадрах, М.Алтан-Очир нар “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа”-ны талаарх бүтээлүүдэд, доктор





ᠮᠤᠩᠭᠡᠯᠡ ᠰᠤᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤᠢ

Ц.Мөнхбатын “Нийтэд тустай ажил хийлгэх ял”, доктор Д.Одсэр “Өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа”

зэрэг томоохон бүтээлүүдэдээ тус тус тусган авч үзэж судалж, шинжлэх ухааны үнэ цэнэтэй бүтээлүүд туурвигдсан хэдий ч өнөөгийн шүүхийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх практикт дээрх ялын хэрэглээнд олон тулгамдсан асуудал хуримтлагдаж, шийдлээ хүлээсэн хэвээрээ байна.

Энэхүү илтгэлийн хүрээнд Хорихоос өөр төрлийн ялын нэг болох нийтэд тустай ажил хийлгэх ялыг хэрэгжүүлэх ажиллагаанаас өсвөр насны хүнд оногдуулсан ялын хэрэгжилтийг судална.

Илтгэлийг боловсруулахдаа ял эдлүүлэх ажиллагааны талаар гаргасан нэг сэдэвт бүтээлүүд болон эрдэм шинжилгээний бүтээл, судалгааны ажлуудыг уншин судалж, дүн шинжилгээ хийж онолын болон эмперик арга буюу анализ хийх, онол, практикт харьцуулалт хийх, статистик мэдээнд дүн шинжилгээ хийх зэрэг аргуудыг ашиглалаа.

Өсвөр насны хүнээр хөдөлмөр эрхлүүлэх нь сэтгэл зүй болоод бие мах бодид эерэг нөлөөлөл үзүүлэх эсэх нь эргэлзээтэй юм. Ажил хөдөлмөр эрхлүүлэхээс илүүтэй насны онцлогт тохируулан хүмүүжлийн доголдлыг засаж залруулах нөлөө үзүүлэх сургалтад хамруулах нь ялын бодлогын үндсэн зарчмыг хангах боломжийг бүрдүүлэх боломжтой гэж судлаачийн зүгээс үзэж байгаа тул энэхүү илтгэлээ бичлээ.

Үндсэн хэсэг

XXI зууны эхэн үеэс эрүүгийн эрх зүйн хэвшиж тогтсон системүүдийн бүтэц, тогтолцоонд үндсэн өөрчлөлт гарсан төдийгүй үзэл баримтлал, бодлого, чиг хандлагын хувьд шинэчлэгдэж, бүхэлдээ хувьсан

өөрчлөгдсөн байна (Есаков, 2005). Өнгөрсөн зууны 80-аад онд дэлхий дахинд эхэлсэн улс төр, нийгэм эдийн засгийн өөрчлөлт нь эрүүгийн хууль тогтоомжийг шинэчлэх давлагааг олон улсад түгээсэн гэхэд болно. 1990-ээд оноос дэлхийн 50 гаруй улсын Эрүүгийн хууль шинэчлэгдсэн. Дэлхийн ихэнх улс орон Эрүүгийн хуулийг хүмүүнлэг, гэмт үйлдлийн шинэ төрлүүдийг эрүүжүүлэх чиг хандлага ажиглагдаж байна (Уранцэцэг, 2014, хууд. 22).

Хүмүүнлэг энрэнгүй ардчилсан нийгмийн үзэл баримтлалыг тулгуурласан улс орнууд цаазын эрүүгийн ялын бодлогоос хасаж, хорихоос өөр төрлийн ялын төрлийг илүүд үзэж, гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах хариуцлагыг хорих, тусгаарлах бус нийгмийн орчинд нь ухамсарлуулан ойлгуулж, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх зан төлөвийг төлөвшүүлэх нь зүйтэй гэсэн байр суурийг баримтлах нь үр дүнтэй гэх чиглэлийг тодорхойлсон байгаа нь ихэнх эрдэмтэн, судлаачдын бүтээлээс харж болно. Академич С.Нарангэрэл: “хорих ялыг ихээр хавтгайруулан оногдуулснаас хорихоос өөр төрлийн ялын нэр хүнд буурч, улмаар уг ял нь гэмт явдалтай тэмцэх үр нөлөөтэй хэрэглүүр болж чадахгүй байдалд хүрнэ” гээд “хорих ялыг хавтгайруулан хэрэглэх нь түүний хамгийн хатуу хүнд ял гэсэн нэр хүндийг бууруулахаас гадна эл ялын сөрөг нөлөөллийг даван туулахад ихээхэн төвөгтэй байдал үүсдэг” (Нарангэрэл, 2008, хууд. 54) гэжээ. Хорих байгууллагад тусгаарлан хорих нь дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх ухамсар төлөвшилийг бий болгохоос илүүтэй тухайн хүний сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж болох юм. Х.И. Албрехт “Шорон бол гэмт хэрэгтнүүдийг бэлтгэдэг их сургууль гэж тэмдэглэсэн байна. Барууны

эрдэмтдийн хийсэн судалгаагаар тухайлбал, Англи Улсад хорих ял эдэлсний дараа болон албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн этгээд дахин гэмт хэрэг үйлдсэн хүний тоо ойролцоо байсан байна (Энхнасан, 2003, хууд. 12) гэж тэмдэглэсэн сонирхол татаж байгаа юм.

Аристотель буянт үйл нь нийт нийгмийн буянт үйл ба эцсийн дүндээ нийт хүн төрөлхтний буянт үйл болно гэж өөрийн бүтээлдээ тэмдэглэсэн байдаг. Тэгэхээр мэдээжийн хэрэг тэр үед буянт үйл бол хүний сайн сайхны төлөө хийж байгаа үйлийг хэлсэн байдаг ч нийтэд тустай ажил хийлгэх нь эцсийн дүндээ өөрт нь хүмүүжлийн нөлөө үзүүлж, өөрт нь сайн үйл болно гэж ухаж ойлгож ч болох юм.

"Токиогийн дүрэм"-ээс эхлээд НҮБ-аас баталсан эрх зүйн баримт бичгүүдэд гэмт хэрэг үйлдсэн хүнийг учруулсан хохирол, эрх зүйн үр дагаврын байдлыг харгалзан ялыг аль болох хамгийн зохистой нөхцөлөөр зөв ногдуулж хэрэглэх нь эрүүгийн эрх зүйн салшгүй нэг чиг үүрэг болсныг онцлон тэмдэглэсэн байх бөгөөд цээрлүүлэх буюу зовоох ялыг аль болох түлхүү хэрэглэхгүй байх, хамгийн үр нөлөөтэй, хорихоос өөр төрлийн ялын төрлийг сонгож, нийгэмд учруулсан хохирлыг нөхөн сэргээх агуулгаар уян хатан, нөхцөл боломжтойгоор хэрэглэх тухай өгүүлсэн байдаг.

Академич С.Нарангэрэл "Эл ялын агуулга нь ялтнаар үндсэн ажил буюу сургалтаас нь чөлөөт цагт нийгэмд ашигтай ажлыг хөлс цалин олгохгүйгээр хийлгэх явдал юм" (Нарангэрэл, 2008, хууд. 18) гэж тайлбарласан. Доктор, профессор Д.Баярсайхан "Нийгмийн тустай ажлыг заавал хийлгэх ял нь цаашид боловсронгуй болж хөгжих ялын төрөлд багтдаг бөгөөд орчин үед нийтэд тустай ажил хийлгэх ялын

хэрэглээ ач холбогдол, үлэмж дээшилсэн нь энэ ялын хэрэглээ нэмэгдэж, тухайн ялын төрлийн альтернатив нөхцөлийг оновчтой тогтоох явдал зайлшгүй болж, олон улс орны өргөн дэмжлэгийг олж байгаа." (Баярсайхан, 2011, хууд. 35) гэж тэмдэглэжээ.

Албадан хөдөлмөр эрхлүүлэхтэй холбоотой ял нь Монгол Улсын эрүүгийн эрх зүй, эрүүгийн хууль тогтоомжид уламжлал болон хэрэглэгдэж ирсэн ба харьцангуй үр дүнтэй гэж үнэлэгддэг. Үүний мөн чанар нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан иргэний ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй холбоотой. Шүүхээс гэм буруутай нь тогтоогдон оногдуулсан Эрүүгийн хуульд заасан аль ч ялын төрөл заавал биелэгдэх учиртай байдаг. Хөдөлмөрийг хүмүүжүүлэх арга хэрэгсэл болгон ашиглах нь хөдөлмөрийн өөрийнх нь нийгмийн мөн чанартай холбоотой гарч ирсэн. Хөдөлмөр гэдэг нь хувь хүнийг төлөвшүүлэх, хөгжүүлэх материаллаг үндэс юм. Хөдөлмөрийн ачаар гэмт хэрэгтэнд нийгэм, хууль ёс, ашиг сонирхолд хүндэтгэлтэй хандах, хөдөлмөрийн ур чадвар эзэмшүүлэх, сахилга хариуцлага, сайн шинж чанаруудыг суулгадаг (Осадчая, 1999). В.А. Сморого "өсвөр насны хүмүүсийг хүмүүжүүлэхэд хөдөлмөр нь хамгийн ач холбогдолтой" гэж тэмдэглэсэн байдаг. Тэрээр хэлэхдээ, хөдөлмөрийн ачаар өсвөр насны гэмт хэрэгтнүүдэд шинэ итгэл үнэмшил, амьдралын шинэ туршлага бий болж, өөрийнхөө төдийгүй хүний хөдөлмөрийн үр дүнд хүндэтгэх хандлага төлөвшдөг гэж үзсэн байна (Сморого, 1980). Хууль зүйн доктор, дэд профессор Ц.Мөнхбат



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ
ТОГТОМЖ



ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰᠤ ᠰᠠᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤᠢ

нийтэд тустай ажил хийлгэх ял нь зорилго, чиг үүргийн хувьд хүмүүнлэгийн шинжтэй нийгэмшүүлэх агуулга бүхий ял бөгөөд энэ ялыг идэвхтэй хэрэглэж буй улс орнуудын туршлага, эрүүгийн эрх зүйн хандлагаас үзэхэд дор дурдсан онцлог шинжийг өөртөө агуулдаг байна гэж тэмдэглэсэн. (Мөнхбат, 2020, хууд. 7)

Судлаачдын үзэж байгаагаар нийтэд тустай ажил хийлгэх ял нь нийгмийн хөгжлийн чиг хандлагыг даган шинэ үр дүнтэй хувьсан өөрчлөгдөж чадаж байх нь Монгол улсын Эрүүгийн хуулийн ялын бодлогын зарчим, үзэл санааг нэг мөр хэрэгжүүлэхэд ач холбогдолтой гэж үзэж байна. Францын нэрт хуульч, эрүүгийн ялын эрх зүйн судлаач Ж.Парадель: “Хорьдугаар зууны сүүлийн арваад жилд хууль тогтоогчдын бодож боловсруулсан хамгийн шилдэг хэлбэр нь нийтэд тустай ажил хийлгэх ял мөн” (Droit, 2002) хэмээн өгүүлжээ. И.В. Дворянсков, В.В. Сергеева, Д.Е. Баталин нар дэлхий дахинд хорих ялаас татгалзаж, хорихгүйгээр гэмт хэрэгтнийг шийтгэх, хариуцлага оногдуулах, цаашид дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх нөлөөллийн үйл ажиллагааны төрлийг нэмэгдүүлэх, одоо хэрэгжиж байгаа арга хэрэгслийг улам боловсронгуй болгох талаар судалсаар байна. (Дворянсков, 2003) гэж дурдсан байна. Монгол Улсад ч гэлтгүй гадаадын олон орнуудад хорих ялаас аль болох татгалзаж, хорихоос өөр төрлийн ялыг оногдуулах, хэрэглэх чиг хандлага байгааг энд дурдах нь зүйтэй. Үүний дотор өсвөр насны хүнийг хөдөлмөрөөр хүмүүжүүлэх чиг хандлага ажиглагдаж байна. Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан: “...гадаадын зарим улс орны Эрүүгийн хуульд “Community service” буюу “Нийгэмд үйлчлэх ял” гэсэн

нэрээр томъёологдсон энэхүү ялын мөн чанар нь тухайн ялтныг нийгмийн хөдөлмөрөөр хүмүүжүүлэхэд оршдог.

Энэхүү ял нь зорилго, мөн чанарын хувьд Монгол Улсад хэрэглэгдэж буй албадан ажил хийлгэх ялтай зарим талаар төстэй...” (Жанцан, 2014, хууд. 23) хэмээн үзсэн. Цаашлаад “... нийгэмд ашигтай ажил гэдэг нь нийт иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн тухайлбал, хот суурины ногоон бүс, цэцэрлэгт хүрээлэнг тохижуулах, гал түймэр унтраах, зам гүүр, үер уснаас хамгаалах далан хамгаалалт тавих зэрэг үйл ажиллагаа байж болно. Нийгэмд ашигтай ажил хийсний төлөө цалин хөлс олгохгүй гэдэгт Хөдөлмөрийн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хийсэн ажилдаа тохирсон хөлсгүй хөдөлмөрлөхийг ойлгоно. Энэ нь энэ ялын нэг гол цээрлэл юм...” (Жанцан, 2014) гэсэн байна. Доктор, дэд профессор Д.Бадам: “...нийгмийн тустай хөдөлмөр эрхлүүлэх нь насанд хүрээгүй хүний хувьд ач холбогдолтой гэж үздэг. Хойд Америкт энэ аргыг түгээмэл хэрэглэдэг ба ажлын байрыг нь орон нутгийн захиргаа, төрийн бус байгууллага, олон нийтийн бүлгүүд олж өгөх, гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүд насанд хүрэгчид болон үе тэнгийнхээ үлгэр дууриаллаас суралцан, хамтран ажиллах бололцоог олгодгоороо ач холбогдолтой гэж үздэг байна. Тухайлбал, тэдгээрээр мод тариулах, орчны цэвэрлэгээний ажилд оролцуулдаг бөгөөд энэ ажлыг скаутын холбоотой хамтран гүйцэтгэдэг” (Бадам, 2017, хууд. 17) гэжээ. Доктор Г.Галсанжамц “Нийтэд тустай ажил хийлгэх ял нь нийгэм, олон нийтэд тулгуурласан (community sentence, community based sentence) эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэж буй сонгох ял (alternative sentence) буюу өнөөгийн бидний өдөр

тутмын хэллэгт тогтмол хэрэглэгдэж буй хорихоос өөр төрлийн ялын (non cusradial sentence) нэгэн адил хэрэглэгдэх нэгдмэл нэршил бүхий ойлголт юм.

Энэ ял нь гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх, түүнчлэн гэмт үйлдлийн засаж залруулах боломжийг илүү олгодог бөгөөд ялын уламжлалт онолын хандлага буюу зөвхөн цээрлэл үзүүлж шийтгэх, “хариу үйлдэл” үзүүлэх явдлыг эрс шүүмжилсэн байхын зэрэгцээ, эдийн засаг, нийгмийн үр өгөөжтэй ял эдлүүлэх тогтолцооны шинэ хэлбэр” гэж үзсэн байдаг.

Дээрхээс дүгнэн үзэхэд нийтэд тустай ажил хийлгэх ял нь ямар нэгэн цалин хөлсгүйгээр нийтийн ашиг тусын тулд чиглэсэн ажлыг хийлгэх, өсвөр насны гэмт хэрэг үйлдсэн хүний хувьд мэдээж нийгмээс тусгаарлалгүйгээр хөдөлмөрөөр хүмүүжүүлэх шинжийг агуулсан ялын төрөл байна. Энэхүү ялын эрх зүйн зохицуулалтыг судлан үзвэл Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт нийтэд тустай ажил хийлгэх ялыг үндсэн ялаар хэрэглэнэ (Эрүүгийн хууль, 2016) гэж заасан байна. Тус хуулийн 5.4 дүгээр зүйлд “гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тусгай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ” гэж тодорхойлсон байна. Тухайн тодорхойлолтоос харахад нийтэд тустай ажил хийлгэх ялын үндсэн шинж нь:

Ял шийтгүүлсэн хүн	2021	2022	2023
Нийт	1518	1552	1467
Насанд хүрсэн	1457	1500	1436
Өсвөр насны хүн	61	52	31

Хүснэгт 1. 2021-2023 онд Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтны харьцуулалт

Насанд хүрээгүй буюу өсвөр насны хүнд оногдуулсан эрүүгийн хариуцлагын бодлогыг судлаачийн хувьд ажиглахад “ёс суртахуун,

- ажлын хугацааг шүүхээс тогтоодог;

- тухайн ажил нь нийтийн ашиг сонирхлын төлөө байх;

- ажил хийснийх нь төлөө ямар нэгэн ажил хөлс олгодоггүй байхад оршдог байна.

Ялын хугацааны хувьд нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан оногдуулдаг. Эрүүгийн хуулийн 66 заалтад нийтэд тустай ажил хийлгэх ялыг оногдуулахаар заасан байдаг. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 13 бүлгийн 57 зүйлийн 66 заалт буюу 14.7 хувьд нийтэд тустай ажил хийлгэх ял ногдуулж болохоор хуульчилжээ (Мөнхбат, 2020, хууд. 7)

Тус ял нь 2017 оноос Монгол Улсын эрүүгийн ялын гүйцэтгэлд хэрэглэгдэж байгаа утга болон агуулгын хувьд албадан ажил хийлгэх ялын боловсронгуй, энэрэнгүй шинжийг агуулсан ялын төрөл юм. Статистик мэдээнээс харахад 2021-2023 онуудад энэ төрлийн ялыг нийт гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүмүүст оногдуулсан ял шийтгэлийн 18.5%-ийг эзэлж байна. Эндээс харахад шүүх энэ төрлийн ял шийтгэлийг өргөнөөр хэрэглэх хандлагатай байгаа нь харагдаж байна.





ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

эрхлүүлэхгүйгээр ял эдлэх хугацаанд сургалтад хамруулж болох юм. Хорихоос өөр төрлийн ялын энэ төрлийг хэрхэн үр ашигтай зохион байгуулах талаар үр дүнтэй үйл ажиллагааг зохион байгуулах нь олон талын эерэг үр нөлөөг нийгэмд үзүүлэх боломжийг бүрдүүлж болох юм.

Монгол Улсын эрүүгийн хуульд заасан ялын нэгэн төрөл болох нийтэд тустай ажил хийх ялын хэрэгжилтийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 162-166 дугаар зүйлд заасны дагуу хууль журмын дагуу хэрэгжүүлж байгаагаас тухайлан авч үзвэл:

Эрүүгийн хуулийн 5.4.1-д “Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ” гэж заасан хэдий ч шүүх шүүхийн шийтгэх тогтоолд ялтны хийж гүйцэтгэх нийтэд тустай ажлыг тусгадаггүй нь энэ ялыг нэг мөр хэрэгжүүлэхэд хүндрэл бий болгож байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163 дугаар зүйлийн 163.6-д шийдвэр гүйцэтгэгч нь ялтныг ажлын байраар хангах тухай мэдэгдлийг шүүхийн шийдвэрийн хамт ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоосон байгууллагад биечлэн хүлээлгэж өгнө гэж заасан нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал нэмэгдэх, ажлын ачаалал үүсгэх нөхцөл байдал үүсгэдэг.

Ялтны хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөө авах эрхийг зөвхөн гэр бүлийн гишүүн хүндээр өвчилсөн, нас барсан, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон бол долоо хүртэлх хоногийн чөлөөг тухайн ял эдэлж байгаа газар хэлтсийн даргын шийдвэрээр олгоно гэж заасан нь хэт хязгаарлалттай харилцааг тусгасан гэж үзэж байна. Энэ нь тухайн хүний

өөрийн эрүүл мэндэд гэнэтийн өвчин эмгэг тусах, хичээл сургалтын гэнэтийн арга хэмжээ, зайлшгүй бусад шалтгаан тохиолдох үед чөлөөний асуудал шийдэгдэхгүй, ялтны эрх зүйн байдлыг ноцтой зөрчиж буй зохицуулалт юм.

Шийдвэр гүйцэтгэгч долоо хоног тутам биечлэн шалгана гэдэг нь хуулийн тусгалаар ойлгоход долоо хоног тутам гэсэн үг. Энэ нь давтамжтайгаар шалгах гэж ойлголт. Долоо хоног тутам шалгах нь ялтан ажил олгогч байгууллагын хууль зөрчих боломжийг бүрдүүлэх нөхцөл юм.

Ял солих үндэслэлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 165 дугаар зүйлд шалтгаангүйгээр ажлаа тасалсан гэх шалтгаан нь хуулийн нэг мөр ойлголт бус юм. Өмнө нь дурдсанаар хуульд заасан чөлөө олгох нөхцөлөөс бусад шалтгаан үүсэж чөлөө хүссэн ялтанд хуулийн зохицуулалт танилцуулан ажлаа хийх шаардлага хууль ёсны дагуу тавихад ажилдаа ирээгүй ялтанд хүндэтгэн үзэх шалтгаангүй ажил тасалсан гэх шалтгаанаар зөрчлийн акт үйлдэх, цаашлаад ял солих санал хүргүүлэх нь хэт хатуу зарчим юм.

Нийтэд тустай ажил хийх ял шийтгүүлсэн ялтан ял эдэлж байх хугацаандаа болон шүүхийн шийдвэр гарснаас хойш ял эдлүүлэх ажиллагаанаас санаатай зайлсхийсэн тохиолдолд эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулж, ялтныг олж тогтоон ял солих шүүх хурал хүртэлх хугацаанд ялтан гадуур сул чөлөөтэй явж байдаг бөгөөд дахин ял эдлүүлэх ажиллагаанаас оргон зайлах эрсдэл өндөр. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны хяналтаас санаатай оргон зайлсан ялтныг хорих ял солих шүүх хурал болох хүртэлх хугацаанд саатуулах эрх зүйн зохицуулалт байхгүй нь шүүхийн

шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэл уяруулж байгаа зэргийг судалж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага байна гэж судлаачийн зүгээс үзлээ.

Дүгнэлт, санал

Дэлхий нийтээрээ эрүүгийн эрх зүйн чиг хандлага хүнийг хорьж цагдах, эрүүдэн шүүх, ял шийтгэлийн байдлаар айлган сүрдүүлэх, үйлдсэн гэмт хэргийн хариуцлагыг хүлээлгэхдээ залхаан цээрлүүлэх, хүнлэг бус хандах зэрэг зүй бус хандлагаас эрс татгалзаж, ялын бодлогын үндсэн зарчим нь гэмт хэрэгтнийг засаж хүмүүжүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдэж болзошгүй бусад хүмүүст дохио санамж хэлбэрээр нөлөөллийг бий болгож гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх нь ялын үндсэн зорилго юм. Өөрөөр хэлбэл дэлхийн ихэнх улс орнуудын эрүүгийн ял шийтгэлийн бодлогын зорилго нь:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

Гэмт хэрэгтнийг хүмүүжүүлж, нийгэмшүүлэх

Нийгэмд шударга ёсыг тогтоох (Алтангэрэл, 2018, хууд. 5) гэх үзэл санааг илэрхийлсэнтэй судлаачийн хувьд санал нийлж байна.

Улс орнуудын эрүүгийн хуульд нийтэд тустай ажил хийлгэх ялын зорилго нийгмийн сайн сайханд чиглэсэн, цаашлаад олон улсын чиг хандлагыг баримтлах, түүнийг өөрийн хууль тогтоомж, эрх зүйн орчинд нутагшуулахад чиглэсэн байна. Эдгээрээс дүгнэж дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

Шүүгч “Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ” гэж

Эрүүгийн хуульд заасны дагуу ялтны хийж гүйцэтгэх нийтэд тустай ажлыг шүүхийн шийтгэх тогтоолд тусгах

Өсвөр насны хүнд оногдуулсан нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагааг сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах. Өсвөр насны хүний бие махбод, сэтгэл зүйн байдал, хүмүүжлийн нөлөөлөл зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр тогтворгүй байсан хэдий ч сургалт, уулзалтын дараагаар сэтгэл зүйд эерэг хандлага үүсэж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байгаа тул ялтан гэх нэршилтэйгээр нийгмийн харилцаанд насанд хүрсэн хүмүүсийн хүрээлэлд ял эдлүүлэх нь нөгөө талаараа хорих ял эдлүүлэхэд нас, хүйсээр ялган хоригдолтой адилтгаж үзэж болох юм. Иймээс ял эдлүүлэх ажиллагааг зохион байгуулалтыг сайжруулах шаардлага үүсч байна. (Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2020)

Өсвөр насны хүнийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудад хууль сахиулах байгууллагууд хамтарсан сургалтыг тодорхой давтамжтай зохион байгуулах тогтолцоог тасралтгүй зохион байгуулах.

Алслагдсан суманд ял эдлэх ялтныг заавал биечлэн хүлээлгэн өгч байгаа нь одоогийн технологийн дэвшлийг нэвтрүүлсэн төрийн үйл ажиллагаанд нийцэхгүй байна. Өсвөр насны ялтны хувийн байдалд дүн шинжилгээ хийж, зарим тохиолдолд цахим технологи ашиглаж ялтан хүлээлцэх ажиллагааг зохион байгуулах нь ажиллагааны зардал, алба хаагчийн ажлын ачааллыг хөнгөвчилсөн зохицуулалт болно.

Нийтэд тустай ажил хийх ял шийтгүүлсэн ялтан шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 164 дүгээр





зүйлийн 164.4-д зааснаар бусад шалтгаанаар тодорхой цаг, хоногоор чөлөө авах зайлшгүй нөхцөл бий болсон тохиолдолд чөлөө олгох асуудал шийдвэр гүйцэтгэх ажиллагааны практикт хуулиас гадуур зохицуулагдаж байгаа. Энэ нь хяналт тавьж байгаа байгууллага болон ялтанд аль алинд нь эрсдэл бүхий үйл ажиллагаа юм. Нийтэд тустай ажил хийх ял шийтгүүлсэн ялтанд чөлөө олгох хуулийн зохицуулалтыг эргэн сайтар тунгааж, “бусад шалтгаан” нөхцөлийн талаар хуульд тусгаж, гурав хүртэлх хоногийн чөлөөг хяналт тавьж байгаа шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн ахлах шийдвэр гүйцэтгэгч олгох эрх зүйн зохицуулалтыг хуульд шингээж өгснөөр ялтны эрхийг хүндэтгэн үзэж ял түргэн шуурхай хуулийн дагуу хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

Ял эдлүүлэх ажиллагаанаас санаатай зайлсхийсэн ялтныг шүүх хорих ял солих саналыг шийдвэрлэх шүүх хурал болох хүртэлх хугацаанд саатуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх.

Ашигласан материал

- Droit, P. J. (2002). *penal compare*. Paris. Dalloz.
- Алтангэрэл, Б. (2018). *Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа*. Улаанбаатар.
- Бадам, Д. (2017). *Насанд хүрээгүй хүнд оногдуулах хорих ялын эрх зүйн зохицуулалт*. Улаанбаатар.
- Баярсайхан, Д. (2011). *Харьцуулсан эрүүгийн эрх зүй*. Улаанбаатар.
- Дворянсков, И. С. (2003). *Применение альтернативных видов наказания в Западной Европе, США и России*.
- Есаков, Г. (2005). *Основы сравнительного условно-правовой науки. Уголовное право*.
- Жанцан, С. (2014). *Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. Ялын тухай сургаал II боть*. Улаанбаатар.
- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Төрийн мэдээлэл эмхэтгэл №25 (Монгол улсын их хурал 2020).
- Мөнхбат, Ц. (2020). *Нийтэд тустай ажил хийлгэх ял*. Улаанбаатар: Чөлөөт хэвлэл сан.
- Нарангэрэл, С. (2008). *Эрх зүйн толь бичиг Хоёр дахь хэвлэл*. Улаанбаатар.
- Осадчая, Н. (1999). *Обязательность работы как новый вид наказания в российском уголовном праве*. Москва.
- Сморыго, В. (1980). *Особенности исправления и воспитания отдельных категорий осужденных : учеб. пособие*.
- Уранцэцэг, Т. (2014). *Эрүүгийн болон эрүүгийн процессын эрх зүй*. Улаанбаатар.
- Мөнхбат, Ц. (2020). *Нийтэд тустай ажил хийлгэх ял: Уламжлал, харьцуулалт, шинэчлэл*. Улаанбаатар.
- Энхнасан, Ж. (2003). *Албадан ажил хийлгэх ялын асуудал*. Улаанбаатар: Хэвлэх үйлдвэр.
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №07 (Улсын их хурал 2016).